

10. Сангийн аж ахуйн яамны зохион байгуулалт, орон тооны тухай № 42	77
11. Аймгийн хөдөө аж ахуйг удирдах газар байгуулах тухай № 44	79
12. Зарим хүнийг ажилд томилох, ажлаас чөлөөлөх тухай № 45	80
13. Багануурын районы талбар авах зарим арга хэмжээний тухай № 49	81
14. Төмөр, Жандавсүрэн нарыг ажилд томилох тухай № 51	82
15. Монгол-Югославын Засгийн газар хоорондын хамтарсан хорооны Монголын хэсгийн даргыг батлах тухай № 55	83
16. Монгол-Югославын Засгийн газар хоорондын хамтарсан хо- рооны Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай № 56	84

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН
ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ЗАРЛИГ**

1980 оны 2 дугаар **№ 43** Улаанбаатар
сарын 14-ний өдөр хот

**БАГАНУУРЫН ХОРООГ РАЙОН БОЛГОН
ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын
Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Багануурын хороог Багануурын район болгон өөрчлөн байгуулсугай.
2. Багануурын район байгуулсантай холбогдуулан районы шүүх, прокурор байгуулсугай.
3. Багануурын районы нутаг дэвсгэрийн хилийн цэсийг 1980 оны 11 хагаст багтаан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдэд оруулан батлуулахыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд даалгасугай.
4. Энэ зарлиг гарсантай холбогдуулан «Багануурын хороо байгуулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 202 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын
Тэргүүлэгчдийн дарга
БНМАУ-ын Ардын Их Хурлын
Тэргүүлэгчдийн нарийн
бичгийн дарга

Ю. ЦЭДЭНБАЛ

Ц. ГОТОВ